



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 28 өдөр

Дугаар А/107

Чөлгөс хот

Тусгай зөвшөөрөл сунгах, зарим  
байгууллагын нэр өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5-ын "г", Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, 18 дугаар зүйлийн 18.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 10 дугаар зүйлийн 10.1.5, 16 дугаар зүйлийн 16.2.2, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3, Эрүүл мэндийн сайдын 2015 оны журам батлах тухай 298 дугаар тушаалын 01 дүгээр хавсралт "Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын ажиллах журам"-ын 2 дугаар хэсгийн 2.6.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Тэргүүлэгчдийн Төлөөлөгчдийн хурлын 2018 оны 53 дугаар тогтоолын 5.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох комиссын 2020 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн эрүүл мэндийн төв, эрүүл мэндийн төвийн дэргэдэх эмийн эргэлтийн сан, хувийн эмийн сан, үүдэн эмнэлгүүдийн эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн хугацааг тус тус 3 жилээр сунгаж, хавсралтаар баталсугай.

2. "Уламжлалт анагаах ухааны болон хүүхдийн сэргээн засах төв" нэрийг "Уламжлалт анагаах ухааны эмнэлэг", "Гурван эрдэнэ" дүрс оношилгооны клиникийн "Эргэх наран бүргэд" ХХК-ний нэрийг "Оточ Сэрвэн" ХХК, "Эмийн эргэлтийн сан" нэрийг "Сум, тосгоны Эрүүл мэндийн төвийн эмийн сан" нэрээр тус тус өөрчилсүгэй.

3. Дээрх эмнэлгийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга /Ц.Гэрэлмаа/-д даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох комиссын дарга бөгөөд аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Г.Лхагвахатан/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

20200228

02  
Аймгийн Засаг даргын 2020 оны  
дугаар сарын 28 өдрийн 1/107  
дугаар захирамжийн хавсралт

Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа  
эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа сунгагдсан  
эрүүл мэндийн байгууллагуудын нэрс

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагын нэр	Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хугацаа дуусах огноо	Тусгай зөвшөөрлийн гэрчилгээг сунгасан хугацаа
1	Баян-Адарга СЭМТ	2020.02.26	3 жил
2	Баянмөнх СЭМТ	2020.02.26	3 жил
3	Баянхутаг СЭМТ	2020.02.26	3 жил
4	Баян-Овоо СЭМТ	2020.02.26	3 жил
5	Батноров СЭМТ	2020.02.26	3 жил
6	Батширээт СЭМТ	2020.02.26	3 жил
7	Галшар СЭМТ	2020.02.26	3 жил
8	Дадал СЭМТ	2020.02.26	3 жил
9	Дархан СЭМТ	2020.02.26	3 жил
10	Дэлгэрхаан СЭМТ	2020.02.26	3 жил
11	Жаргалтхаан СЭМТ	2020.02.26	3 жил
12	Мөрөн СЭМТ	2020.02.26	3 жил
13	Норовлин СЭМТ	2020.02.26	3 жил
14	Өмнөдэлгэр СЭМТ	2020.02.26	3 жил
15	Цэнхэрмандал СЭМТ	2020.02.26	3 жил
16	Жаргалтхаан СЭМТ	2020.02.26	3 жил
17	Бэрх СДЭ	2020.02.26	3 жил
18	Биндэр СДЭ	2020.02.26	3 жил
19	Хэрлэнбаян-Улаан ТЭМТ	2020.02.26	3 жил
20	Тахилгат ТЭМТ	2020.02.26	3 жил
21	Гурванбаян ТЭМТ	2020.02.26	3 жил
22	Өлзийт ТЭМТ	2020.02.26	3 жил
23	Ач манал ӨЭМТ	2020.02.26	3 жил
24	Оюуны шим ӨЭМТ	2020.02.26	3 жил
25	Хэрлэн Дом ӨЭМТ	2020.02.26	3 жил
26	Нэгдсэн эмнэлэг	2020.02.26	3 жил
27	Бор-Өндөр ХНЭ	2020.02.26	3 жил
28	УАУЭмнэлэг	2020.02.26	3 жил
29	Баянхутаг сумын ЭМТөвийн эмийн сан	2019.12.25	3 жил
30	Дэлгэрхаан сумын ЭМТөвийн эмийн сан	2019.12.25	3 жил
31	Мөрөн сумын ЭМТөвийн эмийн сан	2019.12.25	3 жил
32	Батноров сумын ЭМТөвийн эмийн сан	2019.12.25	3 жил
33	Баян-Овоо сумын ЭМТөвийн эмийн сан	2019.12.25	3 жил
34	Норовлин сумын ЭМТөвийн эмийн сан	2019.12.25	3 жил
35	Баян-Адарга сумын ЭМТөвийн эмийн сан	2019.12.25	3 жил
36	Өмнөдэлгэр сумын ЭМТөвийн эмийн сан	2019.12.25	3 жил



37	Бор-Өндөр сумын ЭМТөвийн эмийн сан	2019.12.25	3 жил
38	Биндэр сумын ЭМТөвийн эмийн сан	2019.12.25	3 жил
39	Батширээт сумын ЭМТөвийн эмийн сан	2019.12.25	3 жил
40	Дархан сумын ЭМТөвийн эмийн сан	2019.12.25	3 жил
41	Хэрлэнбаян-Улаан тосгоны ЭМТөвийн эмийн сан	2019.12.25	3 жил
42	Өлзийт тосгоны ЭМТөвийн эмийн сан	2019.12.25	3 жил
43	Гурванбаян тосгоны ЭМТөвийн эмийн сан	2019.12.25	3 жил
44	"БЦС дулаан хайрхан" ХХК-ний 2-р зэрэглэлийн эмийн сан.	2020.02.20	3 жил
45	"Дөңгөл хаус" шүдний клиник	2020.02.20	3 жил
46	"Гурван эрдэнэ" дүрс оношлогооны клиник	2020.02.26	3 жил